

## ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ

(Мэдээлэл, лавлагаа)

*Д.Халиун, Д.Жигваагүнсэл,  
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

Энэхүү лавлагаанд гадаадын зарим улс орнууд Үндсэн хуульдаа<sup>226</sup> засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагатай холбоотой асуудлыг хэрхэн тусгасныг судалсан болно.

*Хүснэгт 1. Гадаадын зарим орнуудын Үндсэн хуульд засаг захиргааны  
нэгжийн удирдлагатай холбоотой асуудлыг тусгасан байдал*

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1	Албани	<p><b>6-р бүлэг. Орон нутгийн засаг захиргаа</b>  <b>108 дугаар зүйл</b>  1. Орон нутгийн засаг захиргааны нэгж нь коммун, муниципалитет болон бүс нутагт хуваагдана. Орон нутгийн засаг захиргааны бусад нэгжийг хуулиар зохицуулна.  2. Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг эдийн засгийн хэрэгцээ, ашиг сонирхол, түүхэн уламжлал дээр тулгуурлан хуулиар тогтооно. Тэдгээрийн хил, хязгаарыг тухайн газар нутгийн оршин суугчдын санал бодлыг авалгүйгээр өөрчилж болохгүй.  3. Коммун болон муниципалитет нь нь орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгж байна. Тэдгээр нь орон нутгийн засаг захиргааны бусад нэгжүүдэд хуулиар олгогдсон эрхээс бусад нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх эрх, үүргийг гүйцэтгэнэ.  4. Орон нутгийн нэгжүүдэд нутгийн өөрөө удирдах эрхийг тэдгээрийн төлөөллийн байгууллага болон орон нутгийн санал асуулгаар дамжуулан хэрэгжүүлнэ. Орон нутгийн санал асуулгыг зохион байгуулах зарчим, процедурыг 151.2-т заасны дагуу хуулиар тогтооно.</p> <p><b>109 дүгээр зүйл</b>  1. Орон нутгийн үндсэн засаглалын төлөөлөх эрх мэдлийн байгууллага нь ерөнхий, шууд, нууц санал хураалтаар дөрвөн жил тутам сонгогддог зөвлөлүүд юм.  2. Муниципалитет, эсхүл коммуны удирдлага нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шууд сонгогдсон Дарга байна.  3. Гагцхүү тухайн орон нутгийн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэд тухайн орон нутгийн зөвлөл болон муниципалитет, эсхүл коммуны даргаар сонгогдох эрхтэй байна.</p> <p><b>110 дугаар зүйл</b>  1. Бүс нутаг нь уламжлал, эдийн засаг, нийгмийн харилцааны хувьд холбоотой, нэгдмэл ашиг сонирхол бүхий орон нутгийн засаг захиргааны хэд хэдэн үндсэн нэгжээс бүрдэнэ.  2. Бүс нутаг нь бүс нутгийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, төрийн бодлоготой уялдуулах нэгж байна.</p>

<sup>226</sup>Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу [www.constituteproject.org](http://www.constituteproject.org) цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

		<p>3. Бүс нутгийн төлөөллийн байгууллага нь Бүсийн Зөвлөл байна. Муниципалитет болон коммуууд нь Бүсийн зөвлөлд өөрсдийн хүн амын тоонд хувь тэнцүүлж, хамгийн багадаа нэг гишүүнийг томилно. Муниципалитет болон коммуны дарга нар нь Бүсийн зөвлөлийн гишүүд байна. Бусад гишүүдийг нь муниципалитет болон коммуны зөвлөл өөрсдийн гишүүд дундаас пропорциональ жагсаалтаар сонгоно. (...)</p> <p><b>114 дүгээр зүйл</b> Сайд нарын Зөвлөл нь бүс нутаг бүрт Префект (Төлөөлөгч)-ийг томилно. Префектийн бүрэн эрхийг хуулиар тогтооно.</p>
2	Болгар	<p><b>135 дугаар зүйл</b> 1. Болгар Улсын нутаг дэвсгэр хот болон бүсүүдэд хуваагдана.</p> <p><b>136 дугаар зүйл</b> 1. Хот нь орон нутгийн өөрөө удирдах байгууллага эрх мэдлээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн суурь нэгж байна. Иргэд орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох болон шууд байдлаар, эсхүл санал өгөх болон орон нутгийн нийтийн хуралд оролцох байдлаар хотын засаг захиргааны үйл ажиллагаанд оролцоно.</p> <p><b>138 дугаар зүйл</b> Орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь Хотын зөвлөл байх ба зөвлөл нь 4 жилийн хугацаатай хотын иргэдээс сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.</p> <p><b>139 дүгээр зүйл</b> 1. Хотын дарга нь хотын гүйцэтгэх удирдлага байна. Хотын дарга хуулийн дагуу 4 жилийн хугацаагаар Хотын зөвлөл, эсхүл орон нутгийн иргэдээс сонгогдоно.</p> <p><b>140 дүгээр зүйл</b> Хот тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн ашиг сонирхлын төлөө зарцуулагдах өөрийн төсөвтэй байна.</p> <p><b>142 дугаар зүйл</b> Бүсийн захиргаа нь үндэсний болон орон нутгийн ашиг сонирхлыг нийцүүлэх, орон нутагт Засгийн газрын үүргийг гүйцэтгэх, бүсийн бодлогыг удирдах үүрэгтэй нутаг дэвсгэрийн нэгж байна.</p> <p><b>143 дугаар зүйл</b> 1. Бүсийн захиргааг бүсийн захирагч/засаг дарга удирдана. 2. Бүсийн захирагчийг Сайд нарын Зөвлөлөөс томилно. 3. Бүсийн захирагчид улсын бодлогыг хэрэгжүүлнэ. Тэд дүрэм, журам болон хуулийн дагуу үндэсний ашиг сонирхлыг хамгаалж хариуцах бөгөөд захиргааны хяналт тавина.</p>
3	Грек	<p><b>IV хэсэг. Засаг захиргаа</b> <b>Бүлэг 1. Засаг захиргааны байгууллага</b> <b>101 дүгээр зүйл.</b> 1. Төрийн захиргааны нэгжүүдийг төвлөрлийг сааруулах зарчим дээр үндэслэн зохион байгуулна. 2. Нутгийн засаг захиргааны нэгжийг гео-эдийн засаг, нийгэм, зам тээврийн нөхцөл байдал дээр тулгуурлаж тогтооно.</p> <p><b>102 дугаар зүйл.</b> 1. Нутгийн захиргааны үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын I, II түвшинд хэлэлцэж шийдвэрлэнэ. Орон нутгийн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ, аль түвшинд хамаарах зэргийг хуулиар тогтооно. Тухайн орон нутгийн байгууллагуудад төрөөс олгосон эрх мэдэл, оногдуулсан үүрэг, хариуцлагыг хуулиар тогтооно. 2. Нутгийн захиргааны байгууллагууд нь засаг захиргааны болон санхүүгийн хувьд бие даасан байна. Хуульд зааснаар орон нутгийн захиргааны удирдлагуудыг бүх нийтийн нууц санал хураалтаар сонгоно.</p>

		<p>3. Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албыг хэрэгжүүлэх болон олон нийтэд үйлчилгээ үзүүлэхэд баримтлах эрх хэмжээ, зайлшгүй болон сайн дурын үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагаа зэргийг хуулиар тогтооно. Төрөөс нутгийн захиргааны байгууллагуудын санал санаачилга, үйл ажиллагааны эрх чөлөөнд халдахгүйгээр хяналт тавина. Тус хяналт нь онцгойлон тухайн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих эрх зүйн хяналтаас бүрдэнэ. Эрх зүйн хяналтыг хуулийн дагуу хэрэгжүүлнэ. Гэмт хэрэгт холбогдсоноос бусад тохиолдолд нутгийн захиргааны удирдлагуудыг албан тушаалаас чөлөөлөх, огцруулах, сахилгын шийтгэл ногдуулахдаа зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг харгалзана.</p>
4	Люксембург	<p><b>Бүлэг 9. Коммун</b> <b>107 дугаар зүйл.</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Коммун нь өөрийн газар нутаг болон өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхлоо хамгаалах байгууллага бүхий хараат бус нэгдэл юм.</li> <li>2. Коммун бүр оршин суугчдаасаа шууд сонгогддог коммуны зөвлөлтэй байна. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч болон тавигдах шаардлагыг хуулиар тогтооно.</li> <li>3. Зөвлөл нь жил бүр коммуны төсвийг тогтооно. Коммун нь өөрийн журмыг боловсруулж болно. Гранд Дюкийн зөвшөөрөлтэйгөөр коммун нь татвар тогтоох эрхтэй. Гранд Дюк нь коммуны зөвлөлийг тараах эрхтэй.</li> <li>4. Коммуныг зөвлөлийн дарга болон гишүүдээс бүрдсэн тэргүүлэгчид удирдана.</li> <li>5. Коммуны харьяа байгууллагуудын бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажилтан, албан хаагчдын эрх хэмжээг хуулиар тогтооно.</li> </ol> <p>Коммуны захиргааны үйл ажиллагаанд хуулиар хяналт тавина.</p>
5	Молдова	<p><b>110 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Молдова Улсын нутаг дэвсгэрийг засаг захиргааны хувьд тосгон, хот, дүүрэг болон Гагаузийн автономит нутаг дэвсгэрт хуваагдана. Хуульд заасны дагуу зарим хотыг муниципалитет гэж зарлаж болно.</li> </ol> <p><b>112 дугаар зүйл. Тосгон, хотын удирдлага</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн бие даасан байдлыг тосгон, хотод хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага нь орон нутгаас сонгогдсон зөвлөл, мэрүүд байна.</li> <li>2. Орон нутгийн зөвлөл, мэр нь хууль тогтоомжийн дагуу бие даасан засаг захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлж, төрийн үйл ажиллагааг тосгон, хотод эрхлэн явуулна.</li> <li>3. Орон нутгийн зөвлөл, мэрийг сонгох, тэдгээрийн бүрэн эрх, үүргийг хуулиар тогтооно.</li> </ol> <p><b>113 дугаар зүйл</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Дүүргийн зөвлөл нь тосгон, хотын зөвлөлийн үйл ажиллагааг дүүргийн түвшинд төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх зорилгоор зохицуулна.</li> <li>2. Дүүргийн зөвлөл хууль тогтоомжийн дагуу сонгогдож, үйл ажиллагаагаа явуулна.</li> <li>3. Орон нутгийн төрийн байгууллагуудын хоорондын харилцаа нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд бие даасан, хууль ёсны, хамтын ажиллагааны зарчимд үндэслэгдэнэ.</li> </ol>

6	Серби	<p><b>176 дугаар зүйл.</b> Иргэд шууд болон сонгууль өгөх замаар эрх мэдлээ хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон автономит аймгийн эрхтэй.</p> <p>Орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон автономит аймаг хуулийн этгээдийн эрхтэй байна.</p> <p><b>180 дугаар зүйл.</b> Ассамблей (Хурал) нь орон нутгийн өөрөө удирдах нэгжийн болон автономит аймгийн дээд байгууллага байна.</p> <p>Ассамблей нь депутатууд болон орон нутгийн өөрөө удирдах нэгжийн зөвлөлийн гишүүдээс бүрдэнэ.</p> <p>Зөвлөлийн гишүүн болон депутатууд хуулийн дагуу Зөвлөл болон автономит аймгийн их хурлын шийдвэрийн дагуу нэрээр, нууц, шууд сонгуулаар 4 жилийн хугацаатай сонгогдоно.</p> <p>Хуулийн дагуу үндэсний цөөнх Ассамблейд пропорциональ байдлаар суух эрх хангагдана.</p> <p><b>188 дугаар зүйл.</b> Орон нутгийн өөрөө удирдах нэгж Белград хот болон хот, тосгонд байна.</p> <p>Орон нутгийн өөрөө удирдах нэгжийн суудал болон нутаг дэвсгэр хуулиар тодорхойлогдоно.</p> <p><b>191 дүгээр зүйл.</b> Хотын хурал (Ассамблей) хуулийн дагуу хотын гүйцэтгэх удирдлагыг сонгуулиар шийдвэрлэнэ. Белград хотын болон тосгоны гүйцэтгэх удирдлагын сонгууль хуулиар зохицуулагдана.</p>
7	Словак	<p><b>64 дүгээр зүйл. Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага</b></p> <p>Муниципалитет нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн нэгж байна. Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах байгууллага нь муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгжээс бүрдэнэ.</p> <p><b>64.а.</b> Муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж нь тухайн нутаг дэвсгэртээ байнга оршин суудаг хүмүүсээс бүрдсэн Словак Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэр, засаг захиргааны бие даасан нэгж юм. Дэлгэрэнгүй зохицуулалтыг хуулиар тогтооно.</p> <p><b>65 дугаар зүйл</b></p> <p>1. Муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн өмч, санхүүгийн нөөцийг бие даан удирдан зохион байгуулах эрх бүхий хуулийн этгээд юм.</p> <p>2. Муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн орлого болон төрийн татаасаар санхүүжигдэнэ. Аль татвар, хураамжийг муниципалитет, аль татвар, хураамжийг дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж ногдуулахыг хуулиар тогтооно. Төрийн татаасыг зөвхөн хуульд заасан хязгаарын хүрээнд олгож болно.</p> <p><b>69 дүгээр зүйл</b></p> <p>1. Муниципалитетын байгууллагууд нь:</p> <p>а.Муниципалитетын зөвлөл,</p> <p>б.Муниципалитетын мэр.</p> <p>2. Муниципалитетын зөвлөл нь Муниципалитетын зөвлөлийн төлөөлөгчдөөс бүрдэнэ. Төлөөлөгчдийг тухайн нутаг дэвсгэрт байнгын оршин суух зөвшөөрөлтэй орон нутгийн иргэд дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Сонгуулийг ерөнхий, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар явуулна.</p> <p>3. Муниципалитетын мэрийг тухайн нутаг дэвсгэрт байнгын оршин суух зөвшөөрөлтэй орон нутгийн иргэд дөрвөн жилийн хугацаагаар ерөнхий, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгоно. Муниципалитетын удирдлага нь мэр байна. Тэрбээр хотын захиргааны ажлыг гүйцэтгэж, муниципалитетыг гадаадад төлөөлнө. Мэрийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө огцруулах үндэслэл, нөхцөлийг хуулиар тогтооно.</p>

8	Унгар	<p><b>41 дүгээр зүйл.</b> Унгарын нутаг дэвсгэр нийслэл хот, мужууд, хотууд болон орон нутаг гэх засаг захиргааны нэгжид хуваагдана.</p> <p><b>42 дугаар зүйл.</b> Мужууд, нийслэл хот болон түүний дүүргүүд, хотууд, орон нутгийн эрх бүхий сонгогчид орон нутгийн удирдлагын эрхтэй байна. Орон нутгийн удирдлага тухайн орон нутгийнхаа хүн амын ашиг сонирхлын дагуу нийтийн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд орон нутгийн байгууллагын бие даасан ардчилсан байдлыг илэрхийлнэ.</p> <p><b>44 дүгээр зүйл.</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Орон нутгийн эрх бүхий сонгогчид санал өгөх замаар өөрсдийн төлөөлөгчдийг орон нутгийн удирдлагад сонгох эрхтэй байна.</li> <li>Дунд хугацааны сонгуулийг тооцохгүйгээр, хотын дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүдийг өмнөх ерөнхий сонгуулийн дараагийн 4 дэх жилийн 10 сард сонгоно.</li> <li>Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх нь ерөнхий орон нутгийн сонгуулийн өдөр дуусна. Хэрэв сонгууль нэр дэвшигчид дутагдалтай байдлаар болохгүй бол орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх нь дунд хугацааны сонгууль хүртэл сунгагдана. Хотын даргын эрх шинэ хотын даргын сонгуулиар дуусгавар болно.</li> <li>Орон нутгийн өөрөө удирдах байгууллага орон нутгийн засаг захиргааны хуульд заасан нөхцөлийн дагуу болон түүний эрхийн хугацаа өнгөрсөн бол татан буугдахаа зарлаж болно. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын татан буугдсаны дагуу хотын даргын эрх бас дуусгавар болно.</li> </ol> <p><b>44/Б.1.</b> Хотын дарга орон нутгийн өөрөө удирдах байгууллагын даргаар ажиллана. Өөрөө удирдах байгууллага дэд даргыг даргын орлогч байдлаар томилж болно. Дэд дарга нь өөрөө удирдах байгууллагын гишүүн байх албагүй боловч орон нутгийн өөрөө удирдах байгууллагын даргыг орлох учир гишүүн байх шаардлагатай.</p>
9	Хорват	<p><b>4-р зүйл.</b> БНХУ-д төрийн эрх мэдлийн хуваарилалт нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн эрх мэдлийн хуваарилалтын зарчимд үндэслэх ба энэ нь энэхүү Үндсэн хуулиар баталгаажсан бүсийн болон нутгийн өөрөө удирдах ёсны эрхээр хязгаарлагдана.</p> <p><b>6-р бүлэг. Бүсийн болон нутгийн өөрөө удирдах ёс</b></p> <p><b>128 дугаар зүйл.</b> Иргэд бүсийн болон нутгийн өөрөө удирдах ёсны эрхтэй байна.</p> <p>Энэхүү эрхээ чөлөөт, шууд, тэгш, нууц санал хураалт бүхий сонгуулиар сонсогдсон төлөөлөгчдөөс бүрдсэн бүсийн болон орон нутгийн төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан эдэлнэ.</p> <p>Иргэд нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хурал цуглаан болон шийдвэр гаргах бусад хэлбэрээр хууль тогтоомжид заасны дагуу оролцоно.</p> <p>Энэ зүйлд заасан эрхийг Европын холбооны иргэд эдэлнэ.</p> <p><b>129 дүгээр зүйл.</b> Хот, тосгон нь орон нутгийн засаг захиргааны нэгж бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээг хуулиар тогтооно. Орон нутгийн засаг захиргааны бусад нэгжийг хуулиар тогтоож болно.</p> <p>Мужууд нь бүсийн засаг захиргааны нэгж мөн бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээг хуулиар тогтооно.</p> <p>Нийслэл хот болон бусад томоохон хотуудыг хуулиар мужид тооцож болно.</p> <p><b>129А зүйл.</b> Орон нутгийн засаг захиргааны нэгж нь иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангах болон орон нутгийн байгууллага, орон сууц, хот төлөвлөлт, олон нийтийн байгууламжууд, хүүхэд асрах, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, бага сургууль, соёл, спорт, галын аюулгүй байдал, хүрээлэн буй орчны хамгаалалт, сайжруулалттай холбогдох өөрийн эрх хэмжээний хүрээний асуудлыг шийдвэрлэнэ.</p>

		<p>Бүсийн өөрөө удирдах байгууллага нь бүс нутгийн ач холбогдол бүхий асуудал, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, газар, хот төлөвлөлт, эдийн засгийн хөгжил, зам тээвэр, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагуудын хөгжилтэй холбогдох асуудлуудыг хариуцан шийдвэрлэнэ.</p> <p><b>129Б зүйл.</b> Бүсийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь хуулиар тогтоосон хүрээнд өөрийн байгууллага, тэдгээрийн эрх хэмжээг иргэдийн хэрэгцээ, шаардлага болон орон нутгийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тогтоох, зохицуулах эрхтэй.</p> <p><b>130 дугаар зүйл.</b> Бүсийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлыг бие даан шийдвэрлэх бөгөөд Үндсэн хуулийн болон хууль ёсны асуудлаар төрийн эрх бүхий байгууллагын хяналтад хамаарна.</p> <p><b>131 дүгээр зүйл.</b> Бүсийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь орон нутгийн орлогыг өөртөө, төвлөрүүлж, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах эрхтэй.</p> <p>Улсаас нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.</p>
10	Чех	<p><b>101 дүгээр зүйл</b></p> <p>1.Муниципалитетуудын удирдлагыг холбогдох төлөөллийг байгууллага нь бие даан хэрэгжүүлнэ.</p> <p>2.Дээд шатны бүс нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагыг тэдгээрийн төлөөллийн байгууллага бие даан хэрэгжүүлнэ.</p> <p>3.Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах нэгжүүд нь эд хөрөнгө өмчлөх эрхтэй, өөрийн төсвийн үндсэн дээр үйл ажиллагаагаа удирдан явуулах нийтийн эрх зүйн хуулийн этгээд юм.</p> <p>4.Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах нэгжийн үйл ажиллагаанд гагцхүү хуулийг сахин хамгаалах шаардлага гарсан тохиолдолд хуульд заасан журмын дагуу төр оролцох боломжтой.</p> <p><b>102 дугаар зүйл</b></p> <p>1. Төлөөллийн байгууллагын гишүүдийг ерөнхий, тэгш, шууд зарчмыг баримтлан нууц санал хураалтаар сонгоно.</p> <p>2. Төлөөллийн байгууллагын сонгуулийн хугацаа дөрвөн жил байна. Төлөөллийн байгууллагын бүрэн эрхийн хугацаанаас өмнө сонгууль явуулах асуудлыг хуулиар тогтооно.</p>
11	Польш	<p><b>15 дугаар зүйл.</b> Нутаг дэвсгэрийн нэгжийг хуулиар тогтооно.</p> <p><b>16 дугаар зүйл.</b> Нутаг дэвсгэрийн нэгжид оршин суугчид нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулна.</p> <p>Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцоно. Хуулиар олгогдсон чиг үүргээ өөрийн нэрийн өмнөөс гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.</p> <p><b>7-р бүлэг. Нутгийн өөрөө удирдах байгууллага.</b></p> <p><b>163 дугаар зүйл.</b> Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь Үндсэн хууль болон бусад хуулиар төрийн бусад байгууллагад олгогдоогүй төрийн чиг үүргийг гүйцэтгэнэ.</p> <p><b>164 дүгээр зүйл.</b> Коммун нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үндсэн нэгж мөн. Бүсийн болон орон нутгийн удирдах ёсны байгууллагын бусад нэгжийг хуулиар тогтоож болно. Коммун нь бусад орон нутгийн удирдах байгууллагад олгогдоогүй нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бүхий л чиг үүргийг гүйцэтгэнэ.</p> <p><b>165 дугаар зүйл.</b> Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь эрх зүйн этгээд байх ба өмчлөх болон түүнтэй холбогдох бусад эрхийг эдэлнэ.</p> <p><b>169 дүгээр зүйл.</b> Нутгийн өөрөө удирдах байгууллага нь үүсгэн байгуулсан болон гүйцэтгэх эрх бүхий байгууллагаар дамжуулан чиг үүргээ гүйцэтгэнэ.</p>

		<p>Үүсгэн байгуулах байгууллага нь бүх нийтийн шууд, тэгш, нууц санал хураалт бүхий сонгуулийн дүнд байгуулагдана. Нэр дэвшигчийг сонгох, сонгууль явуулах зарчим, журам, сонгууль хүчин төгөлдөр болоход тавигдах шаардлага, журмыг хуулиар тогтооно.</p> <p>Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гүйцэтгэх байгууллагыг сонгох, чөлөөлөх зарчим, журмыг хуулиар тогтооно.</p> <p>Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дотоод бүтцийг үүсгэн байгуулсан байгууллагын шийдвэрээр тогтооно.</p>
12	Португал	<p><b>Хэсэг 8. Орон нутгийн засаг захиргаа</b>  <b>235 дугаар зүйл.</b>  1. Орон нутгийн засаг захиргаа нь тодорхой нутаг дэвсгэр, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийг төлөөлөх төлөөлөлтэй байна.</p> <p><b>236 дугаар зүйл. Орон нутгийн засаг захиргааны хуваарилалт</b>  1. Эх газрын орон нутгийн захиргаа нь сум (parish), аймаг (municipality), захиргааны бүсүүдээс бүрдэнэ.</p> <p><b>237 дугаар зүйл. Төвлөрлийг сааруулах</b>  2. Орон нутгийн ассамблей нь тухайн нутаг орноо хөгжүүлэх төлөвлөгөө, төсвийг батлах зэрэг хуулиар ногдуулсан эрх мэдлийг хэрэгжүүлнэ.</p> <p><b>238 дугаар зүйл. Орон нутгийн хөрөнгө болон санхүү</b>  1. Нутгийн захиргаа нь өөрийн хөрөнгө болон санхүүжилттэй байна.  2. Нутгийн захиргааны байгууллага нь өөрийн хөрөнгийг захиран зарцуулсны үндсэн дээр орлогоо бүрдүүлж, үйлчилгээндээ зарцуулах үүрэгтэй.  3. Нутгийн захиргаа нь хуульд заасан нөхцөлийн дагуу татвар тогтоох эрхтэй.</p> <p><b>239 дүгээр зүйл. Шийдвэр гаргах байгууллага болон түүний удирдах зөвлөл</b>  1. Нутгийн захиргаа нь шийдвэр гаргах эрх бүхий иргэдээс сонгогдсон ассамблей болон ассамблейд тайлагнах үүрэг бүхий удирдах зөвлөлөөс бүрдэнэ.  2. Ассамблей нь тухайн нутгийн захиргааны байгууллагад санал хураалтад оролцохоор бүртгэгдсэн нийт иргэдийн шууд, нууц санал хураалтаар пропорциональ буюу хувь тэнцүүлэх системийн дагуу сонгогдоно.  3. Хуульд зааснаар хамгийн олон санал авсан нэр дэвшигч ассамблейн ерөнхийлөгчөөр сонгогдоно. Мөн түүнчлэн ассамблейг сонгох сонгуулийн үйл явц, ассамблей болон удирдах зөвлөлийг бүрдүүлэх хийгээд татан буулгах үндэслэлүүд, хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэргийг хуулиар зохицуулна.  4. Хуульд заасны дагуу орон нутгийн сонгуульд улс төрийн нам, дангаар буюу эвсэл байгуулан, түүнчлэн иргэд бие даан нэр дэвших боломжтой.</p> <p><b>240 дүгээр зүйл. Орон нутаг дахь ард нийтийн санал асуулга</b>  1. Хуульд заасан нөхцөлийн дагуу нутгийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх хүрээний асуудлаар сонгууль өгөх бүртгэлтэй иргэдийн дунд ард нийтийн санал асуулга зохион байгуулж болно.  2. Сонгууль өгөх эрх бүхий иргэд ард нийтийн санал асуулга зохион байгуулах эрхийг хуулиар олгоно.</p> <p><b>242 дугаар зүйл. Захиргааны хяналт</b>  1. Хуульд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагын дараах шатны байгууллага нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.  Нутгийн захиргааны байгууллагыг хууль ноцтой зөрчсөн тохиолдолд тараана.</p>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [http://www.ccre.org/docs/Local\\_and\\_Regional\\_Government\\_in\\_Europe.EN.pdf](http://www.ccre.org/docs/Local_and_Regional_Government_in_Europe.EN.pdf)
- [www.constituteproject.org](http://www.constituteproject.org)

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН